



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 282

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ, 13,333,333.00 (арван гурван сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын Сум дундын ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Д.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашинь улсын дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГӨЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

300401

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны дугаар сарын 19 ний өдрийн
168 дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН
ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Автомашинны нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хьюндай старекс, 45-90 ДГА (арал-кмјwwh7hp6u699888)	2006	168795	20,000,000.00	13,333,333.00	6,666,667.00
	Нийт дүн			20,000,000.00 (хорин сая)	13,333,333.00 (арван гурван сая гурван зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван)	6,666,667.00 (зургаан сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран долоон)